

2011 оны 10 сарын 21-22, 28-29-ний өдрүүдэд болох 4 өдрийн

ТУЗ-ийн гишүүд, хараат бус гишүүд, удирдах ажилтнуудад зориулсан
сертификат олгох сургалт

Оролцогчид:

Тус сургалтанд компанийн гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн гишүүд, захирлууд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн дээд түвшний удирдлага, мэргэжлийн хүмүүс хамрагдана.

Сургалтын агуулга:

Сургалтаар ТУЗ-ийн үйл ажиллагааг үр өгөөжтэй удирдах, захирлуудын цалин урамшууллын бодлого болон гүйцэтгэх удирдлагыг хянах оновчтой тогтолцоо, хууль эрхзүйн хүрээнд мэдээллийн нээлттэй байдлыг ханган ажиллах, сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцлүүд ба хамааралтай талуудын асуудлууд, стратеги боловсруулалт болон манлайлал зэрэг компанийн засаглалын ойлголтуудыг нарийвчлан авч үзнэ.

Сургалтанд хамрагдснаар:

- Компанийн засаглалын дэлхийн шилдэг туршлагаууд,
- Монголын хууль эрхзүйн зохицуулалтын хүрээнд OECD-ийн зарчмуудад нийцсэн компанийн засаглалын тогтолцоог өөрийн компанидаа бий болгох арга зам,
- Хараат бус, гүйцэтгэх бус захирлуудын үүрэг ач холбогдол, захирлуудыг сонгон шалгаруулах үйл явц, ТУЗ-ийн дарга ба гүйцэтгэх удирдлагыг салгах, ТУЗ-ийн хараат бус байдал,
- Хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд ба гүйцэтгэх удирдлага, бусад оролцогч талуудын компанийн засаглал дахь үүрэг хариуцлага,
- ТУЗ-ийн эрх мэдлийн хүрээ, гүйцэтгэх удирдлагыг чиглүүлэх, стратегийг батлах үүргүүд,
- Дотоод гадаад хяналт, мэдээллийн нээлттэй байдлыг ханган ажилласнаар ТУЗ хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах,
- ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүргүүд ба хурлыг үр дүнтэй хэрхэн зохион байгуулах аргуудад суралцах болно.

Сургалтын бүтэц:

Сургалт 12 сэдвээс бүрдэх бөгөөд 4 өдөр үргэлжилнэ. Сургалтын эцэст тестээ шалгалт авна.

Сургалт интерактив байдлаар оролцогчдын асуулт хариулт, кейс сургалт, харилцан бие биенийхээ туршлагаас суралцах боломжийг дэмжих аргаар явагдана.

Байршил: **СЭЗДС-ийн 210 тоот**

Хэсэг I: Компанийн засаглал ба ТУЗ-ийн танилцуулга хичээл

Сэдэв 1: Компанийн засаглалын танилцуулга: Компанийн засаглалын өнөөгийн олон улсын болон Монголын нөхцөл байдал. **(1.5 hrs)**

Зорилго: Компанийн засаглалын ойлголтыг ТУЗ-ийн талаас нь тайлбарлах, Монгол дахь хууль эрхзүйн орчин нөхцлийг тайлбарлах

Сэдвийн хүрээнд: Бизнесийн хэлбэрүүд, Эзэмшил ба хяналтын ангид байдал, Эзэн-Агентын зөрчил, Сонирхлын зөрчлийг шийдвэрлэх арга зам, Компанийн засаглалын ойлголт, тодорхойлолт, түүхэн хөгжил, OECD-ийн компанийн засаглалын зарчмууд, Стратеги боловсруулалт, Эрхэм зорилго ба алсын хараа, Хувьцаа эзэмшигчдэд үнэ цэнэ бий болгох, Сайн засаглалын ач тус, Компанийн засаглалын тогтолцоо, Олон улсын компанийн засаглалын байдал, Монголын компанийн засаглалын нөхцөл байдал

Сэдэв 2: Компанийн засаглалын бичиг баримт, дүрэм журмууд **(1.5 hrs)**

Зорилго: ТУЗ ба түүний хороод, тэдгээрийн дүрэм журмууд, Компанийн бүтэц зохион байгуулалтыг авч үзэх

Сэдвийн хүрээнд: Компанийн дүрэм, журам, Компанийн засаглалын кодекс, Ёсзүйн код ба бусад холбогдох баримт бичгүүд

Хэсэг II: Хувьцаа эзэмшигчид, ХЭХ

Сэдэв 3: Хувьцаа эзэмшигчид **(3 hrs)**

Purpose: Хувьцаа эзэмшигчдийн тэгш эрхийг хангах, хувьцаа эзэмшигчдийн хурлыг үр бүтээлтэй хуралдуулах

Сэдвийн хүрээнд: Хувьцаа эзэмшигчдийн тэгш эрх, Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл ба хурлын явц, Хувьцаа эзэмшигчдийн идэвхжилт, мэдээллийн нээлттэй байдал

Хэсэг III: ТУЗ-ийн хариуцлага, эрх үүрэг

Сэдэв 4: Төлөөлөн Удирдах Зөвлөл **(3 hrs)**

Зорилго: ТУЗ-ийн зорилго, үүрэг хариуцлага, эрх мэдлийн хүрээг тайлбарлах

Сэдвийн хүрээнд: ТУЗ-ийг хэзээ үүсгэн байгуулах вэ, яагаад ТУЗ чухал болох нь, ТУЗ ба гүйцэтгэх удирдлагын ялгаа, Корпорацийн манлайлал ба бизнесийн манлайллын ялгаа, ТУЗ-ийн хэмжээ, бүрэлдэхүүн, гүйцэтгэлийг нь хэмжих нь, ТУЗ-ийн үүргүүд ба эрх мэдэл. Гүйцэтгэх ба гүйцэтгэх бус захирлууд, Хараат бус гишүүд.

Сэдэв 5: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга **(1.5 hrs)**

Зорилго: ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг, хариуцлага, эрх мэдлийн хүрээ, ТУЗ-ийн хурал ба хувьцаа эзэмшигчдийг хурлыг зохион байгуулахад нарийн бичгийн даргын үүрэг, компанийн засаглалын бусад эрх үүргүүдийг авч үзэх

Сэдвийн хүрээнд: ТУЗ-ийн нарийн бичгийн даргын тодорхойлолт, ТУЗ дахь үүрэг хариуцлага, Хороод дахь болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохин байгуулахад ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг, Мэдээллийн нээлттэй байдлыг хангахад ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг, Хөрөнгийн бирж болон бусад зохицуулагч байгууллагуудтай харьцах үүрэг, Компанийн бодлого болон түүнийг сахин мөрдүүлэхэд ТУЗ-ийн нарийн бичгийн даргын гүйцэтгэх

Сэдэв 6: ТУЗ-ийн хурлыг үр өгөөжтэй зохион байгуулж, удирдах **(1.5 hrs)**

Зорилго: ТУЗ-ийн хурлын бэлтгэл, хороодын бүтэц ба үүргүүд, үр өгөөжтэй хурлын зохион байгуулалт болон хурлын хэлэлцэх асуудлууд чухал болох шалтгааныг тайлбарлах, чанартай мэдээллийн урсгал нь зөв шийдвэр гаргах үндэс болох болон хороод ТУЗ-ийн шийдвэр гаргалтын үр нөлөөг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй болох талаар тайлбарлах

Сэдвийн хүрээнд: ТУЗ-ийн хурлын төлөвлөгөө ба зохион байгуулалт, Хурлын хэлэлцэх асуудлуудын жагсаалтыг бэлтгэх, ТУЗ-ийн хороод (аудитын, нэр дэвшүүлэх/цалин урамшууллын, компанийн засаглалын хороод), хороод болж төрөлжихийн ач холбогдол

Сэдэв 7: Компанийн томоохон хэлцлүүд: Сонирхолын зөрчилтэй талуудын гүйлгээ, Их хэмжээтэй хэлцлүүд болон Хяналтын хэлцэлүүдийг авч үзэх **(1.5 hrs)**

Зорилго: Их хэмжээний эсвэл сонирхлын зөрчилтэй хэлцлүүд хийгдэх үед хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хяналтын гүйлгээний компанийн үнэ цэнэд үзүүлэх нөлөө

Сэдвийн хүрээнд: Сонирхлын зөрчлийн тодорхойлолт, үүний эх үүсвэр, Их хэмжээний хэлцэл, Компанийн дүрмийн боловсруулалт, Их хэмжээний хэлцлийг ТУЗ-аас үнэлэх ба батлах үйл явц, Батлах явцад хараат бус захирлуудын үүрэг, Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах алхмууд, сонирхлын зөрчилтэй талуудын хэлцэл, ТУЗ-аас ийм хэлцлийн үед мэдээллийн нээлттэй байдлыг хангах, Хууль эрхзүйн талын шаардлагуудыг ханган ажиллах, ТУЗ-ийн захирлуудын хүлээх хариуцлага, ТУЗ-аас сонирхлын зөрчилтэй талуудын хэлцлийг хянах, Зах зээлийн шударга үнийг тогтоох, тодорхойлох

Хэсэг IV. Гүйцэтгэх удирдлага ба ТУЗ

Сэдэв 8: Гүйцэтгэх удирдлага **(3 hrs)**

Зорилго: Стратегийн удирдлагаар хангах, гүйцэтгэх удирдлагыг чиглүүлэх болон стратегийг хэрэгжүүлэх, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах хоёрын нарийн ялгаа тодруулвал корпорацийн манлайлал болон бизнесийн манлайллын ялгааг авч үзэх

Сэдвийн хүрээнд: Гүйцэтгэх удирдлага дахь ТУЗ-ийн үүрэг, агентын зөрчил, стратеги боловсруулалт, ТУЗ-ийн харилцаа, Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллыг тогтооход ТУЗ-ийн үүрэг, манлайлал, Захирлуудын бизнесийн мэдлэг, Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан ТУЗ-ийн гэрээ

Сэдэв 9: Стратегийн томьёолол ба ТУЗ-ийн үүрэг (3 hrs)

Зорилго: Стратегийг томьёолоход гүйцэтгэх удирдлагын болон ТУЗ-ийн үүрэг, стратегийн хэрэгжилтийг хянах арга замуудыг авч үзэх

Сэдвийн хүрээнд: Стратегийн томьёололд ТУЗ-ийн гүйцэтгэх үүрэг, Стратегийг тодорхойлох үйл явц, алсын хараа, эрхэм зорилго, Стратегийн зорилго, зорилтууд, гүйцэтгэлийн хэмжүүр

Хэсэг V: Мэдээллийн нээлттэй байдал: Санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллүүд

Сэдэв 10: Санхүүгийн бус мэргэжилтэй захирлуудад зориулсан санхүүгийн удирдлага (4.5 hrs)

Зорилго: Мэдээллийг нээлттэй байлгахад шаардагдах санхүүгийн хэрэгслүүд, хувьцаа эзэмшигчдийн өмнө цаг тухай бүрт нь мэдээллийг нээлттэй байлгах ТУЗ-ийн үүрэг, компанитай холбоотой мэдээ материалыг цаг хугацааны хувьд үнэ цэнэтэй, цэгцтэйгээр хувьцаа эзэмшигчдэд хүргэх, ногдол ашгийн бодлогыг тодорхойлох болон хувьцаа эзэмшигчдийн ашгийн хамгийн их болгох зорилгыг биелүүлэхэд хөрөнгө оруулалтын ба санхүүгийн бодлогыг тодорхойлох ТУЗ-ийн үүргүүдийг тус бүрт нь авч үзэх

Сэдвийн хүрээнд: Компанийн санхүүгийн тайлангуудыг унших, ойлгох чадвар, Нээлттэй байдлыг тодорхойлох, Мэдээллийн нээлттэй байдлыг хангах үр дүнтэй аргууд, мэдээллийн үрсгал ба ойлголмжтой харилцааны сувгууд, НББ ба аудитын засаглалд гүйцэтгэх үүрэг, мэдээллийн нээлттэй байдлын оновчтой хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг мэдээллийн нээлттэй байдлаар дамжуулан хангахад ТУЗ-ийн үүрэг, Хөрөнгө оруулалтын болон санхүүгийн бодлогыг тодорхойлох, Ногдол ашгийг тогтооход ТУЗ-ийн үүрэг, үнэ цэнийг бий болгоход дээрх бодлогуудын үзүүлэх нөлөө

Сэдэв 11: Эрсдлийн удирдлага (1.5 hrs)

Зорилго: Компанийн засаглалд эрсдлийн удирдлага яагаад чухал байр суурь эзэлдэг талаар болон эрсдлийн удирдлагын тал дээр ТУЗ-ийн үүрэг хариуцлага ямар байх ёстой талаар тайлбарлах

Сэдвийн хүрээнд: Эрсдлийн удирдлага, Төсөөлөл ба ойлголт, Эрсдлийн удирдлага ба ТУЗ, Эрсдлийн цогц тайлан

Хэсэг VI. Оролцогч талуудтай харилцах харьцаа

Сэдэв 12: Компанийн нийгмийн хариуцлага (1.5 hrs)

Зорилго: Компанийн нийгмийн хариуцлагыг тайлбарлах

Сэдвийн хүрээнд: Компанийн орчин олон улсын хэмжээнд хэрхэн өөрчлөгдөж байгаа нь, оролцогч талуудын онолын үүднээс компанийг авч үзэх нь, Компанийн нийгмийн хариуцлага хэмээх ойлголт, Компанийн нийгмийн хариуцлагыг шүүмжлэгчид

Компанийн ТУЗ-ийн хараат бус захирлуудад зориулсан сургалтын хөтөлбөр

2011 оны 10-р сарын 21-22, 28-29

| | Өдөр 1 | Өдөр 2 | Өдөр 3 | Өдөр 4 |
|---------------|--|--|--|---|
| 8:30 – 10:00 | Нээлт Сэдэв 1: Компанийн засаглалын танилцуулга: Компанийн засаглалын өнөөгийн олон улсын болон Монголын нөхцөл байдал (Yener/Unenbat) | Сэдэв 4: Төлөөлөн Удирдах Зөвлөл (Unenbat) | Сэдэв 8: Гүйцэтгэх удирдлага (Tsend-Ayush) | Сэдэв10: Санхүүгийн бус мэргэжилтэй захирлуудад зориулсан санхүүгийн удирдлага (Accounting/Financial Statements) (Odgerel) |
| 10:00 – 10:15 | Цай кофены завсарлага | Цай кофены завсарлага | Цай кофены завсарлага | Цай кофены завсарлага |
| 10:15 - 12:00 | Сэдэв 2: Компанийн засаглалын бичиг баримт, дүрэм журмууд (Unenbat/Jambaajamts) | Сэдэв 4: Төлөөлөн Удирдах Зөвлөл (Unenbat) Сэдэв 7: Компанийн томоохон болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүд (Jambaajamts) | Сэдэв 9: Стратегийн томъёолол ба ТУЗ-ийн үүрэг (Batjargal) | Сэдэв10: Санхүүгийн бус мэргэжилтэй захирлуудад зориулсан санхүүгийн удирдлага (Dividends & Investment Decisions) (Odgerel/Delgersaikhan) |
| 12:00 – 13:00 | Өдрийн хоол | Өдрийн хууль | Өдрийн хоол | Өдрийн хоол |
| 13:00 – 14:30 | Сэдэв 3: Хувьцаа эзэмшигчид (Unenbat /Yener) | Сэдэв 5: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Oyunbileg/Bolormaa) | Сэдэв 9: Стратегийн томъёолол ба ТУЗ-ийн үүрэг, Тэнцвэржүүлсэн үнэлгээний систем (Batjargal) | Сэдэв10: Санхүүгийн бус мэргэжилтэй захирлуудад зориулсан санхүүгийн удирдлага (Valuation) (Onerjargal/Yener) |
| 14:30 – 14:45 | Цай кофены завсарлага | Цай кофены завсарлага | Цай кофены завсарлага | Цай кофены завсарлага |
| 14:45 – 16:30 | Сэдэв 3: Хувьцаа эзэмшигчид Сэдэв 4: Төлөөлөн Удирдах Зөвлөл (Unenbat /Yener) | Сэдэв 8: Гүйцэтгэх удирдлага (Tsend-Ayush) | Сэдэв 11: Эрсдлийн удирдлага | Сэдэв 12: Компанийн нийгмийн хариуцлага (Khangal) End of Program Exam. |

Dr. Demir Yener

Biographical Background

Dr. Demir Yener is senior financial sector development and corporate governance advisor for USAID in Mongolia since 2008. He is recognized globally for his work in corporate governance.

He pursued an academic career for 26 years and he is a former professor of finance at Babson College (Boston, Mass) and an adjunct professor at Harvard University. He also taught at various universities in many countries, including, the Netherlands, France, Italy, Turkey, Ukraine, Egypt, Bosnia and others, to name a few.

He was Human Capital Development Team Leader for a USAID project in Egypt (2005-2007) prior to his assignment in Mongolia, focusing on quality assurance and accreditation for business and economics educational programs and curricula at Egyptian universities. He has worked as higher education advisor for USAID projects in the Middle East, Eastern Europe and the former Soviet Union on issues in financial sector and corporate governance.

He provided consultancy services for various World Bank, IFC and USAID projects since 1992. His consulting work ranged from financial sector to SME development issues, access to finance, banking sector development, institution building, curriculum development and business education reform initiatives, and corporate governance development in over 30 countries. He helped design and develop training and technical assistance programs in financial sector and corporate governance development. He successfully launched a number of centers of excellence in business education, banking and finance; and corporate governance offering training and educational programs to business leaders and graduate students, and to disseminate best practice knowledge in finance and corporate governance in public advocacy and research.

He has published many articles, concept papers and wrote many assessment reports on corporate governance, financial sector, and emerging capital markets.

Dr. Yener holds BSBA, MBA and PhD degrees in accounting, finance and corporate governance from the Gazi University, Faculty of Business (formerly Ankara Academy of Economics and Commerce, Department of Business Administration) from Turkey, and Syracuse University, USA, respectively.